



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/689

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "б" заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Буянт, Булган, Мянгад сумдад хадлангийн механикжсан салаа байгуулан, газар тариалангийн тоног төхөөрөмж, трактор иж бүрдлийг /хадуур, тармуур, хаман боогч, чиргүүл, үрлэгч/ зээлээр олгон энэ жилийн төлбөрт сум тус бүрээс 5000 ширхэг боодол өвс авахаар гэрээ байгуулан 10-11 дүгээр сард багтаан аймгийн төвд татан төвлөрүүлэх арга хэмжээ авсугай.

2. Тус сумдаас авах 14000 ширхэг боодол өвсийг татан төвлөрүүлж аймгийн үнэ тогтворжуулах, өвсний нөөц сан бүрдүүлж, хөрөнгийн эх үүсвэрээр техникийн зээлийн үнэ барагдуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Гончигсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Аймгийн нөөц өвсийг татан төвлөрүүлэхэд зарцуулагдах тээврийн хөлсийг "Бэлчээр ашиглалтыг сайжруулах" хөтөлбөрт тусгагдсан хөрөнгийн санхүүжилтээс шатахуунаар тооцож гүйцэтгэлээр 4500000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийг хавсралтаар баталснаар Хүнс, хөдөө аж ахуйн газрын дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/689.Ch  
02 03391

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 28-ны өдрийн  
А/689 дүгээр захирамжийн  
хавсралт

БУЛГАН, БУЯНТ, МЯНГАД СУМДААС ГЭРЭЭНИЙ ДАГУУ ТАТАХ  
ӨВСНИЙ ТЭЭВЭР ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	Сум, газрын нэр	Татах рес	Зай /км/	Шатахуун		Нийт зардал
				Тоо /литр/	Үнэ	
1	Булган сум Алаг баг	10	1540	625	2400	1500000
2	Буянт сум Нарийн гол	10	1540	625	2400	1500000
3	Мянгад сум Цагаан булан	10	1540	625	2400	1500000
	Дүн	30	4620	1875	2400	4500000

-oOo-